


ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/020/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цэгц богд төв аудит ХХК-ийн Ахлах аудитор: Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
ГАА-2025/020/НА-СТА-ТШЗ

- Засаг даргын шийдвэргүй эрүүл мэндийн төвийн даргад 3,530.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон,
- Ажилтны цалин орлогыг нийгмийн даатгалын тайланд 3,588.1 мянган төгрөг дутуу тайлагнасан,
- Цалингийн зардлаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлд 15,613.5 мянган төгрөг гүйлгэн зарцуулсан,
- Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 20,391.3 мянган төгрөг хасагдаж орлого төвлөрүүлэх боломжийг алдсан,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор бараа материалыг 61,142.7 мянган төгрөгийн тосллого хийгээгүй, тооллогын бүртгэлээрх хөрөнгийн тооцоог бодоогүй,
- Анхны өртгөө нөхсөн 194,105.1 мянга төгрөгийн үндсэн хөрөнгө байна,
- Үнэ төлбөргүй олгосон 9,596.7 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл орлого аваагүй,
- Хандив тусламжаар 238, 963.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авахдаа акт баримт үйлдээгүй,
- Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны 01/16 дугаартай төлбөрийн акт, 11/27, 10/27 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрүүл мэндийн төв 2024 онд давхардсан тоогоор 4091 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Б/03 дугаар тушаалаар Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн орон тооны хязгаарыг 26 орон тоогоор баталж, гүйцэтгэлээр 22 орон тоотой ажилласан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилт өмнөх оноос 202,199.9 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тоо өссөн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолоор эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэг иргэнээр тооцсон төлбөрийн хэмжээ, өрх сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төлбөр 370,862.6 мянган төгрөгийн нэхэмжилснээс 392,581.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авч, 20,391.3 мянган төгрөг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтаар хасагдаж орлого төвлөрүүлэх боломжийг алдсан байна.

Бусад асуудлын хэсэг

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 зорилт 36 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	121,982.3	241,834.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,431,746.9	1,591,180.6
	Нийт хөрөнгийн дүн	1,553,729.2	1,833,015.0
	Нийт өр төлбөрийн дүн	1,047.3	981.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,552,681.9	1,817,452.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,553,729.2	1,833,015.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	681,913.3	1,157,012.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	732,729.3	892,242.0
	Үйл ажиллагааны үр дүн	(50,816.0)	264,770.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(50,816.0)	264,770.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,600,151.0	1,552,681.9
	Тайлант оны үр дүн	(47,469.1)	264,770.1
	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		
	Эцсийн үлдэгдэл	1,552,681.9	1,817,452.0
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	549,830.5	753,976.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	564,448.3	744,106.5
	Үйл ажиллагааны ЦМГ	(14,617.8)	9,870.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(24,490.0)	(20,489.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(39,107.8)	(10,618.7)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,869.0	15,761.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,761.2	5,142.5
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	803,939.0	763,126.2
	Урсгал зардал	803,939.0	763,126.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	803,939.0	752,507.5
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	751,218.4	716,982.4
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,959.4	35,525.1
	Туслах үйл ажиллагааны орлого		
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,761.2	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 11,095.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Бүртгэл тайлантай холбоотой:** Үнэ төлбөргүй ирсэн 11,095.3 мянган төгрөгийн эм эмнэлэгийн хэрэгслийг орлого аваагүй байна.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах-ыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 95,338.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар 95,338.6 мянган төгрөгийн 12 зөрчил илэрч, 1,867.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 93,471.4 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага, 3 зөрчилд зөвлөмж, өгсөн.

Төлбөрийн акт

Сахилгын шийтгэлтэй хүнд үр дүнгийн урамшуулал 933.4 мянган төгрөг олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-т "Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно", Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" заалттай тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Нэг ажилтанд үр дүнгийн урамшуулал 933.8 мянган төгрөг дутуу олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно" заалттай тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Урамшууллыг нөхөн олгох
төлбөрийн акт тогтоосон

Албан шаардлага

1. Засаг даргын захирамжгүй ЭМТ-ийн даргад 3,530.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" заалттай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан
гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Ажилтны цалингийн орлого 3,588.1 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд дутуу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудын цалинг нийгмийн
даатгалд нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлэв.

3. Цалингийн зардлаас 15,613.5 мянган төгрөг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл рүү гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийн таслан зогсоож давтан
гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Жилийн эцсээр 61,142.7 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй, тооллогын бүртгэлээр байгаа 2,046,162.0 мянган төгрөгийн хөрөнгийн тооцоо бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллого хийж үр дүнг удирдлагын хэмжээнд хэлэлцэж тооцоо бодож үлдэгдийг баталгаажуулах албан шаардлага хүргүүлэв.

5. Үнэ төлбөргүй ирсэн 9,596.7 мянган төгрөгийн эм эмнэлэгийн хэрэгсэл орлого аваагүй, хандив тусламж үнэ төлбөргүй ирсэн 238,963.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан акт баримт үйлдээгүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8-т Төсвийн ерөнхийлөн захирагч тусламж, хандив авсан тухай баримтын хувийг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн санд нэг сарын дотор хүргүүлнэ", Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/203 дугаар тушаалын хавсралт "Тусламж хандиваар эм, эмнэлэгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2-т "Эрүүл мэндийн байгууллага нь тусламж, хандивын эм, эмнэлгийн хэрэгслийг хүлээн авч, эргэлтийн хөрөнгөнд бүртгэн авч, зарцуулалтад хяналт тавина" гэж заасантай нийцэхгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хандив тусламж, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах комисс хүлээн авч байгууллагын даргын тушаалаар нягтлан бодох бүртгэлд авч, албан хаагчдад эд хөрөнгийн картаар эзэмшүүлэн, хадгалалт, хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

6. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2024 оны 01/16 дугаартай төлбөрийн акт, 11/27, 10/27 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралт "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн төвийн дарга Н.Цогдэлгэрт сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 20,391.3 мянган төгрөг хасагдаж орлого төвлөрүүлэх боломжийг алдсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд

бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт:

Анхны өртгөө нөхсөн 194,105.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч нь энэ хуулийн 16.1-д заасан этгээдийн шаардсан тайлбар, тодруулгыг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн гаргаж өгнө", Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.29-т Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-ыг дагаж мөрдөнө./ 4.36-т /Төсөвт байгууллага нь үндсэн хөрөнгийг элэгдлийн нөхөн байгуулан дараах дансны бичилтийг хийнэ./ гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын байдалд дотоод хяналт хийж акталж устгах, цаашид ашиглах хугацааг сунгах талаар арга хэмжээ авч ажиллах

3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитаар Хандив тусламж үнэ төлбөргүй ирсэн 84,263.9 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан акт баримт үйлдэгдээгүй, нягтлан бодох бүртгэлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/203 дугаар тушаалын хавсралт Тусламж хандиваар эм, эмнэлэгийн хэрэгсэл хүлээн авах, хэрэглэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хандив тусламж, үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг комисс томилон хүлээн авч байгууллагын даргын тушаалаар орлого авч ашиглалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		(мянган төгрөгөөр)				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулсан			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дарив сумын ЭМТ	1	11,095.3	1	11,095.3			1	11,095.3				
Дүн	1	11,095.3	1	11,095.3			1	11,095.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

ГАА-2025/020/НА-СТА-ТШЗ

Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын нэр	Нийт зөрчил		(мянган төгрөгөөр)									
			Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дарив сумын ЭМТ	11	95,338.6	2	1,867.2	6	93,471.4	3	-	-	-	-	-
Дүн	11	95,338.6	2	1,867.2	6	93,471.4	3	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		(мянган төгрөгөөр)							
			Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дарив сумын ЭМТ	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-
-Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1				1		
	НИЙТ		1				1		